Зорилт 19. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, амжил хөдөлмөр эрхлэх тавтай нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжлийн хангалтын байгууллаганы үйл ажиллагааг шинэчилж ажлын үр нөлөөг дээшлүүлэх				
178	Хилийн боомтод мэргэжлийн хангалтыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсруулж болгож үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах хангалтыг чангатгах	үйл ажиллагааны хэрэгжилтээр		М.Энхболд Ц.Мөнх-Оргил
178.1	Хилийн боомтод тавих мэргэжлийн хангалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж хил, гааль мэргэжлийн хангалтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, Дархан хил хөтөлбөрийг хэрэгжүүлэх			Ц.Мөнх-Оргил
178.2	Шинээр ашиглалтад оруулсан байнгын болон түр ажиллагаатай хилийн боомтуудыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбож хяналтын ажлын үр дүнг дээшлүүлэх			Ц.Мөнх-Оргил
179	Хил, гааль, цагдаагийн байгууллагуудын ажиллах нөхцөлийг сайжруулж лаборатори байгуулах			Ц.Мөнх-Оргил
180	Хүн амын хүнлэн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн дотоодын болон импортын хүнсний бүх бүтээгдэхүүнд лабораторийн нарийн шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлж хүчин чадлыг нэмэгдүүлэх баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх	лабораторийн шинжилгээнд хамрагдалт Луувар!	70.0	М.Энхболд Ц.Ганхуяг Б.Батсэрээдэнэ
181	Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагаанд тавих хангалтыг эрс сайжруулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр		М.Энхболд Г.Шийлэгдамба Ц.Мөнх-Оргил
Зорилт 20. Онцгой байдлын албыг бэхжүүлж гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох чадварыг дээшлүүлнэ				
182	Улсын нөөцийн байршил, нэр төрөл, тоо хэмжээг шинэчлэн тогтоож мөрдүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр		М.Энхболд Ц.Амгаланбаатар
183	Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулж гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд, штабын сургууль дэдлагыг зохион байгуулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр		М.Энхболд Ц.Амгаланбаатар

184	Гамшгийн энхуулаас урьдчилан сэргийлэх мэдээлэл холбооны орлогог сайжруулах түүний төлөх хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх	-	эрт зарлах мэдээллийн тогтолцоо бүрдэж эхэлсэн	Н.Энхболд Ц.Амгаланбаяр
185	Олон улсын эрэн хийж, арван туслах үйл ажиллагааны тогтолцоонд хамрагдах асуудлыг судалж шийдвэрлэх	-	-	М.Энхболд Ц.Амгаланбаяр
186	Аймаг, нийслэлийн онцгой байдлын хэлтэс, газар, аялал, худалдаа, салбар гаг унтраах болон мэргэжлийн албаар ажиллах төлөх, багаж хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх	-	-	М.Энхболд Ц.Амгаланбаяр
187	Байгалийн гамшиг, үйлдвэрийн ослын үед шаардагдах гамшигийн нөхцлийг бүрдүүлэх	-	-	М.Энхболд Ц.Амгаланбаяр
188	Боловсгуй гамшигийн аюулыг бууруулах чиглэлээр гамшигийн эрсдэл эмсэг байдлын үнэлгээг тогтоол хийж эхэлүүлэх	-	-	М.Энхболд Ц.Амгаланбаяр
189	Иргэд олон нийтэд түүхээрласэн гамшигас хамгаалах үйлдвэрийг хөгжүүлэх	-	-	М.Энхболд Ц.Амгаланбаяр
190	Гамшгийн хяналт шалгалтын ажлын баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх	-	-	Ц.Амгаланбаяр
Зурга - Засгийн эрх зүйн шинэчлэл				
Зорилт 21 - Эрдий засаг, нийгмийн бүх хүрээнд хариуцалтын тогтолцоог эрс дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал чөлөөтэй шуурхай хүргэж ил тод байдлыг хангахад амьц гаргана				
191	Иргэний эрх, эрх чөлөө, шударга ёс, ил тод байдлыг баталгаажуулсан хууль хяналтын тогтолцоог бүрдүүлж эрдийн засгийн хөгжлийн чадвархийг нэмэгдүүлэх	-	-	Ц.Мөнх-Орлор Ч.Улаан
191.1	Иргэдийнхээ өмч хөрөнгийг капитал болгож үнэ цэнэ оруулан эргэлттай болгох, түүнийг нь хамгаалах	2007.12- 2008.07	-	М.Энхболд Ц.Мөнх-Орлор Засгийн газрын гишүүд Аймаг нийслэлийн Засаг дарга
191.2	Уламжлалт мэдлэг, технологийг аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтаар хамгаалах эрх зүйн орчинг бий болгох чиглэлээр холбогдох зам байгууллагууд хариуцсан чиглэлээр судалгаа хийж санал боловсруулах	2007.12- 2008.07	-	М.Энхболд Ц.Мөнх-Орлор Засгийн газрын гишүүд Аймаг нийслэлийн Засаг дарга
192	Бүх салбартай байгаа хариуцлага тооцох механизм эрх зүйн үндсийг дахин нэгтгэн үзэж чангатгах, боловсронгуй болгох	-	-	Ц.Мөнх-Орлор Засгийн газрын гишүүд
192.1	Төрийн үйлчилгээний төлүүдээр стандарт тогтоох судалгаа явуулж боломжтой стандартыг тогтоон мөрдүүлэх арга хэмжээ авах	2007.12- 2008.07	-	Н.Энхболд М.Энхболд Засгийн газрын гишүүд
192.2	Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгуулалын үйлчилгээний стандартыг боловсруулан батлуулж хэрэглэгчийн эрхийн баталгаа сэтгэл ханамжийн байдал судалгаа хийж дүнг нэгтгэн холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан удирдлагад танилцуулах	2007.12- 2008.07	-	Ц.Мөнх-Орлор
192.3	Төрийн байгуулалтын шинэчлэлийн хүрээнд, төрийн байгуулалын орчны дүн шинжилгээ явуулж түүний мөрөөр төрийн захиргааны төв байгууллагуудын үйл ажиллагааны стратегийн зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг нэгдсэн арга зүйгээр шинээр боловсруулах ажлыг зохион байгуулж түүнийг батлах бэлтгэлийг хангаж мэдээллийг нэгтгэд ил тод болгон Засгийн газрын вэб хуудсаар мэдээлэх	2007.12- 2008.07	-	Н.Энхболд Засгийн газрын гишүүд
192.3.1	Бизнесийн захиалгат судалгааны ажлыг гэрээ захиалгаар хэрэгжүүлдэг механизм бий болгох	2007.12- 2008.07	-	М.Энхболд Н.Болоржаа

Аймаг нийслэлийн Засаг дарга			
192.4	2007.12-2008.07	Н.Энхболд Засгийн газрын гишүүд	Төрийн албыг төр-иргэдийн харилцан итгэлцэл хамтын ажиллагааны төгс илэрхийллийн төвшинд хүргэж төрийн чадавхийг сайжруулан төгөлдөршүүлэх. Төрийн байгууллагын зарим чиг үүргийг нутгийн захиргаа, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус болон бизнесийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, бараа, бүтээгдэхүүн үйлчилгээ худалдан авах хүрээг өргөжүүлэх, төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, зүүлэх үйлчилгээний стандарт, шалгуурыг тогтоож өгөх.
192.4.1	2007.12-2008.07	М.Энхболд Н.Энхболд	Олон нийтийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах хэрэгсэлчдийн эрхийг хамгаалахад чөлгөсөн гадаад орнуудын стандарт дүрэм журмыг судалж хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангах зорилгоор бүх салбарт үндэсний стандартыг олон улсын жишигт хүргэж чиглэл боловсруулах ажлыг зохион байгуулах.
192.4.1.2	2007.12-2008.07	М.Энхболд Н.Энхболд	Ерөнхий сайдын 2007 оны 13 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Ояч, чухал объектын хөрүүл хамгаалалтын болон байдлын түвшинг тодорхойлох норматив"-ыг судлан орчин үеийн шаардлагад нийцүүлэх ажлыг зохион байгуулах.
192.4.1.3	2007.12-2008.07	М.Энхболд Ж.Норовсамбуу Ч.Улаан	Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн шинжилгээг Төрийн албаны зөвлөл Сангийн яамны оролцоотойгоор дотоод, гадаадын шинжлэх мэргэжил хамтран гүйцэтгэж тэдгээрийн чиг үүргийг боловсронгуй болгох санал боловсруулан шийдвэрлүүлэх ажлыг дэс дараатайгаар хэрэгжүүлэх.
192.4.1.4	2007.12-2008.07	Ч.Улаан	Засгийн газрын байгууллагуудад худалдан авах ажиллагааны удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээний тусгай програмыг хангамжийг нэвтрүүлэх замаар зохиолч байгууллагын худалдан авах ажиллагааг төлөвлөх удирдан зохион байгуулах, бүртгэх, тайлагнах үйл явцад цахим сүлжээ ашиглах боломжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.
192.4.1.5	2007.12-2008.07	Ч.Улаан Н.Энхболд	Засгийн газрын төндөрийн үйл ажиллагаанд цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.
192.4.1.6	2007.12-2008.07	Ч.Улаан Н.Энхболд	Төрийн байгууллагуудын 2008 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг баталж олон нийтийн хэлэлц мэдээллийн хэрэгсэлээр зарлах, гүйцэтгэлд хяналт тавих, Засгийн газрын цахим сүлжээнд худалдан авах ажиллагааг бүртгэх үр дүнг хянах.
192.5	2007.12-2008.07	С.Баяр Засгийн газрын гишүүд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд нь Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Улс төрийн нэгдүгээр тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах.
193	2007.12-2008.07	С.Баяр Засгийн газрын гишүүд	Төрийн албаны хүнд суртлыг багасгах замаар төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах төрийн албан хаагчдын ёс зүйн, амы хэмжээг тогтоож харууцлага хүлээлгэх зарчмыг тодорхой болгох арга хэмжээг авах.
193.1	2007.12-2008.07	Н.Энхболд Ж.Норовсамбуу	Төрийн байгууллагуудын дүр төрх төрийн албан хаагчдын сэтгэлгээний төгөлдөршилгйг цаг алдалгүй эрчимтэй шинэчлэх.
193.1.1	2007.12-2008.07	Н.Энхболд Ж.Норовсамбуу Х.Норовсамбуу	Төрийн байгууллагын бүх шатны албан хаагчдад ёс зүйтэй ажиллах өрд түмэндээ чин үнэнчээр үйлчлэх сэтгэлгээг хэвшүүлэх.

193.1.1	Төрийн тусгай албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм түүнийг сахуулах арга хэрэгшүүрийн байдалд судалгаа дуусалт хийж туршлагыг нийтлэн хүртээл болгох	-	2007.12-2008.07	Н.Эмболд Ж.Норовсамбуу
193.2	Төрийн байгууллагын доод, дунд, дээд шатанд арга түмнээсээ элдэв шэн харамж гарсаар дургам замаараар дарамталдаг чирэгдүүдэд түүнээс аялгын сулнээс босгодог тогтворзас олон орлогоо хувьдаа зарцуулдаг үйл явдлыг таслан зогсоох	-	2007.12-2008.07	Ц.Минх-Оргил
193.2.1	Нийтээр дэгж мөрдөх зарим шийдвэрийг журамлах тухай санал боловсруулан шийдвэрлүүлж хэрэгжүүлэх	-	2008.07.23	Ц.Минх-Оргил Засгийн газрын гишүүд
193.2.2	Нийтээр дэгж мөрдүүлэх шийдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2007 оны 324 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулах	-	2007.12-2008.07	Н.Эмболд Засгийн газрын гишүүд Ж.Норовсамбуу
193.2.3	Төрийн байгууллагын үйл ажиллагаа (байгууллагын ноомттой байдлыг харуулахын тушаан хуулийн зорилгын үйл ажиллагааны гүйцэтгэлийн байдал) -нд түвшин тогтоож хэлэлцэж мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл болгох	-	2007.12-2008.07	Н.Эмболд Засгийн газрын гишүүд
193.2.3.1	Хамнаас иргэдтэй шууд харилцах "Намын ноомттой өдөр" -ийг баталгасан журамтай дагуу сэр бүр зохион байгуулах	-	2007.12-2008.07	Н.Эмболд Засгийн газрын гишүүд Ц.Минх-Оргил
193.2.3.2	Цагдаагийн байгууллагад "итгэх иргэдийн итгэл, сэтгэл ханамж" -ийн байдал нийгэмд жордог уур амьсгал буй болгох, гэжт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах чиглэлээр цагдаагийн байгууллагаас хийж байгаа аялал чанар, үр дүнг судлах	-	2007.12-2008.07	Н.Эмболд Засгийн газрын гишүүд Ж.Норовсамбуу
193.2.3	Төрийн захиргааны ба төрийн үйлчлэлтэний албаны нийгэмд үзүүлэх аялал чанар хүртээмжийн байдлыг хэрэгсэлтийн үүсгэлээ өгөж, санал асуулга явуулах нэгдсэн арга зүйг хандивалч орон олон улсын байгууллагатай хамтран боловсруулах	-	2007.12-2008.07	Н.Эмболд Засгийн газрын гишүүд Ж.Норовсамбуу
193.2.4	Сайбарын төрийн албан хаагчдын мэдлэг мэргэшил, үр чадварыг бийрэг дэвшүүлж иргэдэд шуудтай үйлчилж санал хүсэлтийг төрийн хууль тогтоомж дүрэм журмын дагуу байбарлан таниулах тэрийн дамжиж туслах үүрэгтэй гэсэн сэтгэлзэний төлөвшил бий болгож хэвшүүлэх	-	2007.12-2008.07	Ц.Гантуяа
193.2.5	Хүний эрхийн гэрээ хэлэлцээрийн биелэлтийн тухай үндэрсний илтгэлийг болгох ажлыг зохион байгуулах	-	2007.12-2008.07	С.Оюун
193.3	Төрийн байгууллагын бүх шатны албан хаагчид аливаа үйлчлэлтэй ямар нэг хүнд суртал, чирэгдэлгүй хэрэг хариулиас өндөг явуулах боломжийг бүрдүүлэх	-	2007.12-2008.07	Н.Эмболд Засгийн газрын гишүүд
193.4	Төрийн албан хаагчдаас иргэдэд үйлчлэхээр мөрдөх албаны болон ёс зүйн хэм хэмжээг аялалч байдлыг тодорхойлолтод тусгаж байгууллага бүрийн өвө хуудсанд ноомттой тавьж өл тод байрлах	-	2007.12-2008.07	Н.Эмболд Ж.Норовсамбуу
193.5	Байгууллагын дотоод сүлжсэн дээр суурилсан дотоод үйл ажиллагаа бичиг хэрэг хөтөлгөөний онглон болгох "E-Office" системийг Хууль, зөв, дотоод зөргийн яаманд нэвтрүүлсэн туршлагыг судалж үр програмийг хөгжүүлэх бусад яам газарт нэвтрүүлэх эмсэл тавих	-	2008.01.07	Н.Эмболд Ц.Минх-Оргил Засгийн газрын гишүүд
193.5.1	Нам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны таллан гаргах үзүүлэлт арга зүй боловсруулж болгож байгууллагын үйл ажиллагааны талланг байгууллагын БСБ хуудсанд тавьж түүнд хяналт-шигшээгээ үүсгэлээ хийж аялалч цахим хэлбэр шилжүүлэх эмсэл тавих	-	2007.12-2008.07	Н.Эмболд Засгийн газрын гишүүд Ж.Норовсамбуу
193.5.2	Нам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага бүр 2007 оны үйл ажиллагааны талланг гаргаж өвө хуудсанд тавих	-	2008.01.03	Н.Эмболд Засгийн газрын гишүүд Ж.Норовсамбуу

194	Улаанбаатар хотод төрийн албан ахуйн үйлчилгээний хэрэгцээнд 100 километр 13 литрээс илүү түлээ хэрэгцээг хөдөлгүүрийн цөмийн баялаг, итэй автомашин хэрэглээийг хязгаарлах.			Засгийн газрын гишүүд Т.Билэгт
194.1	Яам, агентлаг болон аймал, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын удирдах албан тушаалтны албан ахуйн суудлын авто машин хэрэглэх эрх, түүний ашиглалтын үр ажиллах	2007.12-2008.07		Ч.Улаан Н.Энхболд
195	Яам, агентлагийн болон төрийн захиргааны дунд, доод шатны түвшинд бүтцийн өөрчлөлт хийж цэвэрхон чадварлаг удирдлагын бүтэц бий болгох			Н.Энхболд
196	Орлогоороо санхүүгээр агентлагуудыг төсвийн санхүүжилтээр санхүүгээр зарчмал шалгуулах			Н.Энхболд Ч.Улаан
197	Аймагийн төлөөлөгчид болон аймгийн төмд сонхон оршдог сумдаг засаг захиргааны нэгжийн шинэчлэл хийх асуудлыг шийдвэрлэх			М.Энхболд
198	Сумдын Засаг даргын Тамгын газрын ажиллах нөхцөлийг сайжруулах боловсон хүчний чадвархий сайжруулах ажлыг үн шалтгайгаар зохион байгуулах		үйл ажиллагааны хэргажилтээр	Н.Энхболд
199	Бие хүний өвчлөлд, гарын хурууны хээ, нүдний цэцгийн ругалтын мэдрэллийн үгсэн нэгдсэн сан байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх			Ц.Мөнх-Оргил
200	Сонгуулийн хууль, тогтоомжийг боловсруулж болгож сонгуулийн хууль тогтоомж зарчмалд аялгууна сонгууль зохион байгуулж буй ажилтанд хүлээлгэх харуцлагыг өндөржүүлэх			Ц.Мөнх-Оргил
200.1	Сонгуулийн талбаруудыг шинэчлэн төлөвдөржүүлэх харуцлагын мөхөөмөл гүдэрхий болгож			Ц.Мөнх-Оргил
200.1.1	Засгийн газруудын үйл ажиллагааны үр дүнг Засгийн газрыг тэргүүлсэн Ардчилсан ажилласан буй намуудтай оролцсон МААН, уг Засгийн газрын бүрэлдэхүүнд орж харуцлага галах эрхтэй бүрдүүлэх	2007.12-2008.07		С.Оюун
200.1.1.1	Гараад оронд орсон суугаа иргэдийнхээ саналыг алдаг орууудан туршилтыг судлах			С.Оюун
200.1.2	Сонгуулийн тогтолцоог Үндсэн хуулийнхаа ерөнхий агуулга, үзэл санаатай нийцүүлэх			Н.Энхболд Ц.Мөнх-Оргил
200.1.2.1	2008 оны сонгуулийн дараа Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах			Н.Энхболд Н.Энхболд Ц.Мөнх-Оргил
200.1.3	Парламентын эсэргэлтэн хэлбэрийг улам төгөлдөржүүлэх			Н.Энхболд Ц.Мөнх-Оргил
200.2	Сонгуулийн хуулийг төлөвдөржүүлэх			Н.Энхболд Б.Баттулга
200.2.1	Сонгуулийн мажоритар тогтолцоо нь нэр дэвшигчийг хялалт нэгж бие дэвшсэн байдалтай болгооны өөрчлөх			Н.Энхболд Б.Баттулга
200.2.1.1	Улс төрийн намуд, бүрэн төлөвшсөөгүй өнөөгийн нөхцөлд мажоритар тогтоосон тогтоосон сонгууль явуулах болтолгийг сайтар хангах ажлыг зохион байгуулж амжиллах			Н.Энхболд Б.Баттулга
200.2.1.2	Гараад орууудан сонгуулийн хуулийг илгил хэлээр өгж сонгуулийн тогтолцооны харьцуулсан судалгааг нэгтгэн холбогдох байгууллагууд хүргүүлэх			С.Оюун
200.2.2	Улс үндэснийхээ эрх ашгийг төлөөлж Учиртай ард түмний элч-парламентын гишүүд аймаг орон нутгийн аж ахуйн асуудлыг мөөрөгдөж болж хувирсныг өөрчлөх	2007.12-2008.07		С.Оюун
		2008.06		С.Баяр Ч.Улаан Д.Дэмбэрэл

200.2.2.1	Сонгуулийг төмөрсөн тайвтароор оруулах нөхцөлд бус лугал тайргийн нийгмийн хөгжлийг тэтгэхэд чөлөөтэй нарийн үйл ажиллагааны нэгдмэл хөтөлбөргийгээр сонгуульд оролцоход зарчмыг баримтлах ажиллах	-	2008.06	С.Баяр Ц.Улаан Д.Дэмбэрэл
200.2.3	Төрийн албыг улс төрийн намдын нөлөөнөөс бүрэн ангижуулах	-	2007.12- 2008.07	Ц.Мөнх-Оргил Н.Энхболд Ж.Норовсэмбүү
200.2.3.1	"Төрийн албаны тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөл батлагдсаны дараа Төрийн албаны зөвлөлтэй хамтран хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах	-	2007.12- 2008.07	Ц.Мөнх-Оргил Н.Энхболд Ж.Норовсэмбүү
200.3	Сонгуулийн инвентар системийг зайлшгүй өөрчлөн төгөлдөршүүлэх	-	-	Н.Энхболд Б.Баттулга
200.3.1	Бэлэг сэлт, хатуулаг, санал худалдан авах оролцлогуудыг шалтгаалан сонгуулийн шуудгар зарчим алдагдсан болон иргэдийн чөлөөт ухаалаг сангалт хийх боломж хязгаарныг залуулах	-	-	Н.Энхболд Б.Баттулга
200.3.2	Сонгуульд оролцох улс төрийн намуудын хамтын ажиллагааг ирвөөхүүлэх арга хэмжээ авах уламжар сонгуулийг шуудгар агуулах зарчмыг мөрдөж ажиллах	-	-	Н.Энхболд Б.Баттулга
201	Монгол Улсын Их Хурлын 2008 оны ээлжит сонгуулийн өмнө хүн амын бүртгэл тооллогын тоо, мэдээнийг зөрүүг эргүүлж, бүрдмэнтэй болгох	-	-	Ц.Мөнх-Оргил
201.1	Иргэний бүртгэлийн болон улсын хөлийн асуулах байдлын санхүүгийн байгууллагуудад нэгтгэгдэн системжэгдсэн бүртгэлийн тогтолцоотой болох	-	2007.12- 2008.07	Ц.Мөнх-Оргил Н.Энхболд П.Бамбацэцэн Засгийн газрын гишүүд Аймаг нийслэлийн Засаг дарга
201.1.1	Хүн амын өмчийн болон хөлийн бүртгэлийн жагсаалтыг аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо тус бүрээр гаргаж иргэдийн хөлийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах	-	2007.12- 2008.07	Ц.Мөнх-Оргил Н.Энхболд П.Бамбацэцэн Засгийн газрын гишүүд Аймаг нийслэлийн Засаг дарга
201.1.1.1	Гаднадад байрлаа оршин суугаа монгол иргэдийн бүртгэлийг эргүүлж арга хэмжээ авах	-	2007.12- 2008.07	С.Оюун Ц.Мөнх-Оргил П.Бамбацэцэн
201.1.2	Иргэний бүртгэлийн тухай хуулийн төсөл болон "Иргэний бүртгэлийг сайжруулах арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан батлуулах хэрэгжилтийг улсын хэмжээнд хангах	-	2007.12- 2008.07	Ц.Мөнх-Оргил П.Бамбацэцэн
201.1.3	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгал (гарын) Цэргийн штабуудад цэргийн тоо бүртгэл хөтөлж арга хөтөлбөрийг боловсруулах болгох хүрээнд "Цагийн мэдээллийн сан" бий болгож боломж нөхцөлийг бүрдүүлэх	-	2007.12-2008.07	Ж.Баттууг
201.2	Монгол Улсын төрийн бүх байгууллагуудын бүртгэл тооцооны өнөөгийн байдлаа үнэлж мэдээ нэгтгэн ашиглах боломжийг бүрдүүлэх	-	2007.01- 2008.07	Н.Энхболд П.Бамбацэцэн Засгийн газрын гишүүд

201.2.1	Дэргэйн банкны санхүүгийн тусламжаагаар Монгол Улсын бүртгэл санхүүгийн ахлын өнөөгийн байдалд үзэлгээ хийгээж түнц дүнлэлт гаргуулах ажлыг зохион байгуулах	-	2007.01-2008.07	Ч.Улаан П.Бямбацорон
201.2.2	Статистик мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах, хүрээг өргөжүүлэх замаар нийгмийг унэн зөв мэдээлэлээр хангах тогтолцоог эргэн хөнгөх	-	2007.01-2008.07	Н.Энхболд П.Бямбацорон
202	Гэмт хэргэ гэм буруутгай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зохистой механизм эрх зүйн үндсийг бүрдүүлж мөрдүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ц.Мөнх-Оргил
203	Цэгдээгийн байгууллагын эрх бүхий албан тушаалтдаас тогтруулийг болон мөнгөнд хяналтээр өндөгүүлж байгаа журмыг өөрчлөж талбар тооцрог болон бусад эрхий асуудлыг шийдвэрлэх мөрдөх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ц.Мөнх-Оргил
204	Иргэний бүртгэл, мэдээлэл шилжих мөдөлгөөн, гадардын иргэн харьяатын асуудлаарги төрийн үйлчилгээг нэгдсэн сүлжээнд оруулж иргэдэд шуургай үйлчлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ц.Мөнх-Оргил
204.1	Гараадын иргэдийн бүртгэлийн системийг төвлөрдөржүүлж бүртгэлийг зургагтай болгох Монголд оршин суух хуацаа дуусмагц бүртгэлийн програмд тухай бүр дохиолол өгдөг болгох асуудлыг судалж шийдвэрлэх	-	-	Ц.Мөнх-Оргил
204.2	Иргэний бүртгэл, паспорт хяналтын нэгдсэн сүлжээ төслийг хэрэгжүүлж эхний ээлжинд Монгол Улсын хилээр эрх гэрч, байгаа Монгол Улсын харьяат болон гадардын иргэдийн бүртгэлийг онлайн сүлжээгээр хангах ажлыг зохион байгуулах	-	-	Ц.Мөнх-Оргил
204.3	Иргэний бүртгэлийн нэгдсэн сүлжээ төслийн хүрээнд 21 аймаг, 9 дүрлэйд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн нэгдсэн сүлжээнд холбох	-	-	Ц.Мөнх-Оргил
204.4	Монгол Улсын хилээр эрх гэрч буй тээврийн хэрэгсэлийн бүртгэлийг олон улсын байнгын ажиллагаатай хийийн шалган нэлгэрүүлэх босголд нэлгэрүүлж 20 боомтыг байнгын ажиллагаатай болгох	-	-	Ц.Мөнх-Оргил
204.5	Орон нутаг дахь иргэний бүртгэлийн ажилтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах	-	-	Ц.Мөнх-Оргил
205	Хууль, тогтоомжийн хоорондын зөрчлийг судлан арилгах арга хэмжээг эзлүүлэх	-	-	Ц.Мөнх-Оргил
205.1	Хууль, тогтоомжийн хоорондын зөрчлийн талаар судалгаа хийж санал болгосруулах	-	-	Ц.Мөнх-Оргил
205.2	Боловсрогдаж байгаа хуулийн төсөл Хуульч сонгон шалгаруулах, Орчуулган эрх олгох болон Төрийн бус байгууллага Удирдорчийг эвлэл, эвлэл мэдээлэл, шашны байгууллагыг бүртгэх журмыг Хууль эрх, дотоод хэргийн яамны цахим санд байгуулах, сонирхсон иргэд Түүнтэй танилцах боломжоор хангагдах	-	2007.12-2008.07	Ц.Мөнх-Оргил
206	Засаглал, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Улсын Их Хурлын байнгын хороодыг орчин үеийн төлөх хэрэгслээр хангах	-	-	Н.Энхболд
207	Сумдад цагдаагийн kobан барих ажлыг эрчимжүүлэх	kobаны тоо	80	Ц.Мөнх-Оргил
207.1	Цагдаагийн kobан барих сумдын нэрийг тогтоож гүйцэтгэлийг шалгаруулан ажлыг зохион байгуулах	-	-	Ц.Мөнх-Оргил

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН НИЙТЭЭР ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ХЭМ ХЭМЖЭЭ, ЗАРЧМЫГ ШҮҮХИЙН ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлд зааснаар олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим болон Монгол Улсын олон улсын гэрээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг бөгөөд Монгол Улс нь олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудын нэг болох **"гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх"** зарчмыг баримтлах талаар Үндсэн хуулийн мөн зүйлийн 2 дахь хэсэгт тунхаглажээ.

Олон улсын гэрээ нь олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх гол хэрэгсэл болж, төрийн болон төрийн бус байгууллагын, тэдгээрийн дотор үндэсний эрх зүйн харилцааны субъектуудын оролцоотой олон улсын харилцааг өргөжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах салбарт анхдагч үүрэг гүйцэтгэдэг билээ.

Ийм учраас олон улсын гэрээний заалтыг дотоодод хэрэгжүүлэхтэй холбоотой шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.3-т заасныг удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:**

1. Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ болон Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан.

"Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах" эрх нь Үндсэн хуулиар олгогдсон иргэний үндсэн эрхийн нэг тул хүний эрх, эрх чөлөөг хангах, эдлүүлэх асуудал шүүхийн шүүн таслах ажиллагааны үйлчлэлийн хүрээнд нэгэн адил хамаарна. Хүний эрх, эрх чөлөө нь хуулийн утга, агуулга, түүний хэрэглээг тодорхойлсний зэрэгцээ хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжиж, шүүн таслах ажиллагаагаар хангагдан хамгаалагдана.

Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим гэж олон улсын эрх зүйн үндсэн агуулгыг илэрхийлэх, улс хоорондын хэвийн ажиллагааг хангахад чухал ач холбогдол

бүхий хууль зүйн дээд хүчин чадалтай, улс орнуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хэлнэ.

Тухайлбал, хүний эрхийг бүх нийтээр хүлээн зөвшөөрч, хүндэтгэх, олон улсын үүргээ шударгаар биелүүлэх зэрэг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд хамаарна.

Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ гэдгийг олон улсын хамтын нийгэмлэгээс тогтоож, хүлээн зөвшөөрсөн, хууль зүйн хувьд заавал даган биелэгдэх хүчин чадалтай зан үйлийн дүрэм гэж ойлгоно.

Дээрх зарчим болон хэм хэмжээний агуулгыг Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагуудын баримт бичигт дэлгэрүүлсэн байж болно.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэж заасны дагуу олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг болно.

БНМАУ-аас тусад улс оронтой байгуулсан болон нэгдэн орсон олон улсын хүчин төгөлдөр гэрээ Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй бол Монгол Улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг байна.

Олон улсын гэрээг Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д "Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ" гэж тодорхойлжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч болон Засгийн газар Монгол Улсын нэрийн өмнөөс улс хоорондын, Монгол Улсын Их Хурал парламент хоорондын, Монгол Улсын Засгийн газар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар өөрийн нэрийн өмнөөс Засгийн газар хоорондын, Монгол Улсын

яам, агентлаг өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газрын нэрийн өмнөөс Засгийн газар хоорондын олон улсын гэрээг тус тус байгуулна.

Яам, агентлаг, тэдгээрийн харьяа байгууллага, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагаас бусад улсын ижил төрлийн байгууллага, хувь хүн, хуулийн этгээдтэй өөрийн нэрийн өмнөөс байгуулсан гэрээ Олон улсын гэрээний тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

3. Олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үндэсний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай талаар олон улсын гэрээнд өөрт нь тусгайлан заасан бол үг гэрээний заалт Монгол Улсын нутаг дэвсгэрт шууд үйлчилнэ (өөрөө биелэгдэх швэнж).

Харин гэрээний оролцогч улс орнууд энэхүү гэрээнд нэгдсэнээр өөрийн үндэсний хууль тогтоомжид холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай талаар олон улсын гэрээнд өөрт нь тусгайлан заасан бол үг гэрээний заалт Монгол Улсын нутаг дэвсгэрт шууд үйлчлэх боломжгүй юм.

Шүүх эрүүгийн хэрэг, иргэний болон захиргааны эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхдээ хүчин төгөлдөр болсноор заавал даган мөрдөх шинжийг агуулсан, албан ёсоор нийтлэгдсэн, дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардсан заалтыг, Үндсэн хуульд харшлаагүй, үндэсний эрх зүйн харилцааны оролцогч этгээдүүдэд шууд эрх, үүрэг үүсгэх чадалтай Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.

Үндэсний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэрээг шүүх эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд шууд хэрэглэх боломжгүй. Харин энэхүү заалтын дагуу дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон бол шүүх үндэсний хууль тогтоомжийг баримталж, хэргийг шийдвэрлэнэ.

4. Шүүхүүд олон улсын гэрээнд тусгагдсан эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхдээ тухайн гэрээ хүчин төгөлдөр болсон эсэхийг анхаарвал зохино.

Олон улсын гэрээ нь гэрээнд заасан, эсхүл хэлэлцээрт оролцсон талуудын тохиролцсон журам болон хугацаанд хүчин төгөлдөр болдог тул гэрээнд ийм заалт байхгүй, эсхүл талууд энэ талаар тусгайлан тохиролцоогүй бол Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн 1969 оны Конвенцийн 24 дүгээр зүйлд зааснаар гэрээнд

оролцогч улс орон бүр гэрээг заавал даган биелүүлэхийг хүлээн зөвшөөрснөө илэрхийлсэн тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр болно.

Монгол Улс бүрэн эрх олгогдсон этгээдээр дамжуулан Олон улсын гэрээний тухай хуульд заасан арга, хэлбэрээр тухайн гэрээг байгуулна. Үүнд:

- гэрээнд гарын үсэг зурах
- гэрээг бүрдүүлэх баримт бичиг солилцох
- гэрээг соёрхон батлах
- гэрээг батлах
- гэрээнд нэгдэн орох зэрэг арга хэлбэрүүд багтана.

Түүнчлэн олон улсын тухайн гэрээ Монгол Улсын хувьд хүчин төгөлдөр болсон эсэх нь түүнийг хэрэглэхэд онцгой ач холбогдолтой.

Олон улсын гэрээг байгуулсан, эсхүл түүнд нэгдэн орсон улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болох журмыг гэрээнд тусгайлан заасан байвал олон улсын гэрээ өөрөө хүчин төгөлдөр болсон хэдий ч тухайн улс орны хувьд зөвхөн энэ журмын дагуу хүчин төгөлдөр болно. Тухайлбал, гэрээнд гарын үсэг зурж, нэгдэн орсны дараа соёрхон баталсан улс батламж жуух бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гэрээнд заасан хугацааны дараа тухайн улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болох журам олон Конвенц, гэрээнд тусгагджээ.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогч дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ", хорин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно", тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "Улсын Дээд шүүх, бусад шүүх нь ...албан ёсоор нийтлэггүй хуулийг хэрэглэх эрхгүй", Олон улсын гэрээний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1-д "Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан олон улсын гэрээг нийтлэхдээ Монгол Улсын хууль нийтлэх журам, олон улсын бусад гэрээг нийтлэхдээ Засгийн газрын тогтоол нийтлэх журмыг тус тус баримтлана" гэж тус тус заасныг үндэслэн шүүхүүд хүчин төгөлдөр болсон олон улсын гэрээнүүдээс зөвхөн албан ёсоор нийтлэгдсэн гэрээг хэрэглэнэ.

Олон улсын гэрээ хүчин төгөлдөр болсон хэдий ч албан ёсоор нийтлэгдээгүй бол шүүх түүнийг хэрэглэхгүй.

Олон улсын гэрээний 25 дугаар зүйлийн 2-т "олон улсын гэрээг гадаад харилцааны асуудал эрхлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн тусгай эмхтгэл болгон хэвлэж байна". Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4 -т "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхэд "Төрийн мэдээлэл" эмхтгэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ", мөн зүйлийн 43.5-д "Төрийн мэдээлэл" эмхтгэлд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаарх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, яам, агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг бүрэн эхээр нь нийтэлнэ" гэж тус тус заасны дагуу Гадаад хэргийн яамнаас олон улсын гэрээг албан ёсоор орчуулсан эхийг "Төрийн мэдээлэл" сэтгүүлд хэвлэн нийтэлснийг "олон улсын гэрээний албан ёсны нийтлэл" гэж үзнэ.

Монгол Улсын олон улсын гэрээ хүчин төгөлдөр болсон тухай мэдээллийг Гадаад хэргийн яам гаргаж өгнө.

6. Монгол Улсын олон улсын гэрээг эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхүүд дараах тохиолдолд шууд хэрэглэнэ:

6.1. Иргэний болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд: шүүхийн хэлэлцүүлгийн зүйл болж буй маргаантай харилцааг зохицуулсан материаллаг эрх зүйн дотоодын хуулийн зүйл, заалтаас олон улсын гэрээний зохицуулалт өөр байгаа бол;

6.2. Эрүүгийн байцаан шийтгэх болон иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд: шүүн таслах ажиллагааг явуулах эрүү, иргэн, захиргааны процессын эрх зүйн дотоодын хуулиар тогтоосон журмаас өөр журмыг олон улсын гэрээ тогтоосон бол;

6.3. Эрүүгийн байцаан шийтгэх болон иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд: шүүхийн хэлэлцүүлгийн зүйл болох харилцаа (тэдгээрийн дотор гадаадын этгээдийн оролцоотой) зөвхөн олон улсын гэрээгээр зохицуулагдаж байгаа бол;

6.4. Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд: захиргааны хариуцлагын тухай дотоодын хууль тогтоомжид заасан зохицуулалтаас олон улсын гэрээний зохицуулалт өөр байгаа бол.

Ингэхдээ Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас өөр журам тогтоож байгаа олон улсын гэрээг заавал соёрхон батлахаар Олон улсын гэрээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т заасныг шүүхүүд анхаарвал зохино.

7. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.-д "Үйлдэл, эс үйлдхгүйг гэмт хэрэгт тооцог, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн энэ хуулиар тодорхойлно" гэж заасан тул Эрүүгийн хуульд тусгайлан заасан тохиолдолд л эрүүгийн гэмт хэргийн шинжийг тодорхойлсон олон улсын эрх зүйн хэм хэмжээг шүүхүүд хэрэглэж болно.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 299 дүгээр зүйлд "Олзлогдоггод, энгийн хүн амтай харгис хэрцгий харьцсан, хүн амыг оршин суугаа нутгаас нь албадан зайлуулсан, эзлэгдсэн нутагт түүх соёлын үнэт зүйлийг тонон дээрэмдсэн, эзвэсэгт мөргөлдөөний үеэр Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон арга хэрэгсэл хэрэглэсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Монгол улсын олон улсын гэрээгээр хориглосон хүн амыг үй олноор нь хөнөөх, устгах эзвэсэг хэрэгсэл хэрэглэсэн бол арван таваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж заасан тул энэ зүйлд заасан гэмт хэргийн объектив талыг тодорхойлоход Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай 1968 оны Конвенци, Дайны талбарт байгаа эзвэсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн(I) Конвенци, Дайнд олзлогдоггодтой харьцах тухай Женевийн (III) Конвенци зэрэг олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн гэрээний заалтуудыг шүүхүүд шууд хэрэглэх боломжтой байна.

Эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тусгасан хэм хэмжээ бүхий олон улсын гэрээнд үндэсний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар гэрээний хэрэгжилт хангагдах талаар заасан байдаг тул Эрүүгийн хуульд заагдаагүй гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлсон Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг шүүхүүд хэрэглэхгүй.

8. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.-т "Гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа этгээд болон дагаж мөрдөж байгаа хууль, олон улсын гэрээний дагуу Монгол Улсын шүүхэд эрүүгийн хэргийн талаар харьяалагдахгүй бусад этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдвэл түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх

асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ” гэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 193 дугаар зүйлд “Гэдаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлдэг иргэн болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд сайн дураар зөвшөөрснөөс бусад тохиолдолд Монгол Улсын шүүхийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарагдахгүй.

Монгол Улсын төрийн болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах байгууллагын урилгаар Монгол Улсад зочилж байгаа гадаад улсын төлөөлөгч, дагалдан явца бусад зөвмүүс Монгол Улсын шүүхэд үл харьяалагдана” гэж тус тус заасныг Дипломат харилцааны тухай Венийн 1961 оны Конвенц болон Консулын харилцааны тухай Венийн 1963 оны Конвенцийн зүйл, заалттай харьцуулан үзэж, эрүүгийн хэрэгт холбогдсон этгээд иргэний хэргийн зохигч болон хэргийн бусад оролцогч дархан эрх, давуу эрх, эрх ямбын алиныг нь ямар хэмжээгээр эдлэх ёстой болохыг тодорхой тохиолдол бүрт шүүхүүд зааглан ялгаж байвал зохино.

9. Монгол Улсын олон улсын гэрээнд хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөхөөр Иргэний, Гэр бүлийн, Хөдөлмөрийн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиуд болон бусад хуульд заасныг Үндсэн хуулийн арвдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогч дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасантай уялдуулан зөвхөн соёрхон баталсан олон улсын гэрээ дотоодын хуулиас дээгүүр хүчин чадалтай байна гэж ойлгоно.

Өөрөөр хэлбэл хууль хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн олон улсын гэрээ л дотоодын хуулиас илүү хүчин чадалтай байх буюу олон улсын гэрээний зохицуулалт хуулийн зохицуулалтаас өөр байвал олон улсын гэрээний заалт үйлчилнэ.

Монгол Улсын хуулиар соёрхон батлагдаагүй олон улсын гэрээ түүнийг байгуулсан төрийн тухайн байгууллагын хууль тогтоомжийн эрхийн актуудаас дээгүүр хүчин чадалтай байна.

10. Олон улсын гэрээг тайлбарлахад Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн 1969 оны Конвенцийн зохицуулалтыг шүүхүүд баримтална. (III анги, 31 – 33 дугаар зүйл)

Олон улсын гэрээг тайлбарлахад хүндрэл учирвал Нэгдсэн Үндэстний байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын болон олон улсын бусад байгууллагын шийдвэр, эрхийн актыг ашиглах,

олон улсын гэрээний хүчинтэй байх хугацаа, гэрээнд оролцогч улсын бүрэлдэхүүн, гэрээг хэрэглэж буй олон улсын практик зэрэг асуудлаар Гадаад хэргийн яамны гэрээ, эрх зүйн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас навлагаа авч байвал зохино.

11. Гадаад улсын шүүхийн даалгаврыг биелүүлэх, гадаад улсад шүүхийн даалгавар явуулах иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхүүд хэрэгжүүлэхдээ гадаадын тухайн улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх Монгол Улсын хоёр талт олон улсын гэрээ, ийм гэрээ байхгүй бол Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай 1954 оны Конвенцийн зүйл, заалтыг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтын хамт баримтална.

Иргэн, гэр бүлийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын хоёр талт олон улсын гэрээ нь нарийвчилсан зохицуулалттай, харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 1954 оны Конвенц нь ерөнхий зохицуулалттай гэрээ болно. Хоёр талт гэрээгээр тусгайлан зохицуулсан асуудалд Конвенцийн энэ талаарх заалтыг баримтлах шаардлагагүй ба харин хоёр талт гэрээнд тусгайлан зохицуулаагүй асуудлаар Конвенцийн заалтыг баримтлана.

12. Гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам нь Монгол Улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан буюу нэгдэн орсон Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлогдоно.

Монгол Улс тухайн гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээнд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх асуудлыг тусгасан бол гэрээний уг заалт болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2., Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт зааснаар шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай эрх бүхий этгээдийн хүсэлтээр шийдвэрлэнэ.

Монгол Улс тухайн гадаад улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй, эсхүл уг гэрээнд шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай асуудлыг тусгаагүй бол гадаад улсын шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах асуудлыг шүүх шийдвэрлэхгүй.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай 1954 оны Конвенцийн III бүлэгт шүүхийн бүх шийдвэрийг гүйцэтгэх талаар бус харин шүүхийн зардал төлүүлэх шийдвэрийг

биелүүлэх талаар тусгасан байх тул шүүхийн зардал төлүүлэх тухай гадаад улсын шийдвэрийг албадан гүйцэтгэх асуудлыг шүүхүүд Монгол Улс тухайн гадаад улстай хоёр талт гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран Конвенцийн заалтыг баримтлан шийдвэрлэнэ.

Гадаад улсын шүүхийн шийдвэр гэдэгт тухайн маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг ойлгоно. Албадан гүйцэтгүүлэх шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон, шийдвэрийн үнэн зөв байдал нь түүнийг гаргасан шүүхээр баталгаажсан, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг тухайн шүүх зөвшөөрөн дэмжиж байгаа, шийдвэрийн эх албан ёсоор орчуулагдсан, зохих журмын дагуу ирүүлсэн байх шаардлагатайг шүүхүүд анхаарвал зохино.

Гадаадын арбитр буюу арбитрын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай хүсэлтийг Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1958 оны Конвенцийн зүйл, заалтын дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт зааснаар шүүхүүд шийдвэрлэнэ.

Гадаад улсын шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэснээр Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулж болзошгүй, Монгол улсын нийтийн эрх зүйн дүрэмд харш, эсхүл зохигчдын хоорондох тухайн маргааныг Монгол Улсын шүүх хянан шийдвэрлэж, шүүхийн хүчин төгөлдөр өөр шийдвэр гарсан, эсхүл иргэний хэрэг үүсгэгдэн, хянан хэлэлцэгдэж байгаа, тухайн хэрэг Монгол Улсын шүүхийн онцгой харьяалалд хамаардаг, эсхүл гадаад улсын шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болоогүй буюу хүчин төгөлдөр болсон эсэх нь тодорхой бус, шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх талаар шаардлага тавих хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бөгөөд энэ хугацаа сэргээгдээгүй зэрэг нөхцөл байдал тогтоогдвол гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай сонирхогч этгээдийн хүсэлтийг шүүх хангахаас татгалзаж, энэ талаарх үндэслэлийг шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд тодорхой заана.

13. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Улсын Дээд шүүхийн Тамгын Газарт даалгах нь:

13.1. Хүний эрхийн Үндэсний комисс, Гадаад хэргийн яамны гэрээ, эрх зүйн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран Монгол Улсын олон улсын гэрээний албан ёсны орчуулга, гэрээний жагсаалт, тэдгээрийн хүчинтэй байх хугацаа, хүчин төгөлдөр болсон хугацаа, Монгол Улсын нэгдэн орсон хугацаа, албан ёсоор хэвлэн нийтлэгдсэн байдал зэрэг асуудлаар нийт шүүх, шүүгчдийг үнэн, зөв мэдээллээр цаг алдалгүй хангаж байх.

13.2. Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвтэй хамтарч шүүгчдийн болон шүүхийн ажилтнуудын үргэлжилсэн, давтан сургалтад олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ болон Монгол Улсын олон улсын гэрээг судлах, сургалтын материал гарын авлагаар хангах, сургалтын хөтөлбөрт оруулах зэрэг асуудлыг онцгой анхаарч ажиллах.

13.3. Улсын Дээд шүүхийн Эрүүгийн, Иргэний, Захиргааны хэргийн танхимууд болон Судалгааны төвтэй хамтран олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж буй шүүхийн практикийг судлаж, нийт шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны хүрээнд судалгаа, сургалтын ажил зохион байгуулах

14. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтыг лавлагааны журмаар ашиглахыг нийт шүүх, шүүгчдэд мэдэгдсүгэй. /Эдгээр хавсралтыг Улсын Дээд шүүхийн вэб сайт <http://www.supremecourt.mn>-аас үзнэ үү /

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ **С.БАТДЭЛЭГЭР**

**ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН** **ЦАМАРСАЙХАН**

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН** **Б.БАТСАЙХАН**

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН** **О.ЗАНДРАА**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265058
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 5